



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/276.

Ховд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн “ж”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2021 оны 6 дугаар сарын 09-ний өдөр, архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 17:00 цагаас 6 дугаар сарын 11-ний өдрийн 24:00 цаг хүртэл хугацаагаар хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, сумдын Засаг дарга нар, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ